

СТРАТЕГИ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЭЧЛЭЛ,  
ХУУЛИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН ОЮУНБААТАРЫН МӨНХЗАЯАГИЙН  
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
<b>Зорилт 1. “НЭГ. “ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</b>							
1.	Арга хэмжээ 1.1 Салбарын хуулийн төсөл болон эрх зүйн бусад баримт бичгийн төслийг холбогдох албан хаагчидтай хамтран шинэчлэн боловсруулахад дэмжлэг үзүүлэх.	Шинээр боловсруулсан эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулахад холбогдох нэгжид дэмжлэг үзүүлсэн байна.	-	30%	Боловсролын яам, Гэр бүл, хөдөлмөр,нийгмийн хамгааллын яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Хууль зүй, Дотоод хэргийн яам нараас хамтран боловсруулж буй “Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай” хуулийн төсөл боловсруулах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Боловсролын сайдын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/171 дүгээр тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж тус хуулийн үзэл баримтлалын төслийг батлуулах ажлын хүрээнд нийт 3 удаагийн ажлын хэсгийн хуралд оролцож хуулийн төсөл болон, үзэл баримтлалын төслийг дахин боловсруулах асуудлаар санал хүргүүлсэн.Ухаалаг засаг 2 төслийн хүрээнд хэрэгжүүлж буй “Цахим шилжилтийн талаар хууль тогтоомжийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах” зөвлөх үйлчилгээний төслийн гүйцэтгэлийг хянаж,	03.12-06.06	50%

					<p>хүлээн авах үүрэг бүхий Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/72 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд <b>мэргэжилтэн</b> ажиллаж тайлант хугацаанд 4 удаагийн ажлын хэсгийн хуралд оролцож санал хүргүүлсэн. Виртуал бүсэд бүртгэлтэй этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журмын төсөл боловсруулах үүрэг бүхий "Тогтвортой хөгжил, бодлого судалгааны ногоон хөгжлийн гарц" НҮТББ-тай 2025 оны 03 дугаар сарын 20-ний өдөр байгуулсан Ү/05 дугаартай Үйлчилгээний гэрээ мөн Хиймэл оюун ухааны хөгжүүлэлтийн төв байгуулах ажлын даалгавар боловсруулах үүрэг бүхий "Эй Ай Ризирч" ХХК-тай 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан Ү/03 дугаартай Үйлчилгээний гэрээний хэрэгжилтэд Захиргааны ерөнхий хууль болон тус ажлын даалгаварт хамаарах хууль, эрх зүйн орчныг дахин судлах шаардлагатай талаарх саналыг Инновацын бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн.</p>		
2.	Арга хэмжээ 1.2. Хуулийн төсөл, Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх.	Хууль тогтоомж, тогтоолын төсөлд салбарын асуудлыг тусгах саналыг тухай бүр хуулийн хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	-	30%	<p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон бусад яамдаас боловсруулсан хуулийн төсөл, Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газрын тогтоолын төсөлд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын саналыг тухай бүрд хүргүүлж ажилласан. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хуулийн төсөл-16</li> <li>• Монгол Улсын Их хурлын төсөл-1</li> <li>• Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл-4</li> <li>• Журмын төсөл-1</li> </ul>	03.12-06.06	50%

3.	Арга хэмжээ 1.3. Яамны дотоод үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг боловсруулах, батлуулах.	Байгууллагын хэмжээнд шаардлагатай журмуудыг хуулийн хүрээнд боловсруулж, батлуулсан байна.	-	30%	“Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын шагнал олгох, шагналын сан бүрдүүлэх журам”-ын төслийг найруулж сайдын шийдвэрээр, “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны гадаад албан томилолтын журам” болон журмыг дагалдан гарах маягтын төслийг боловсруулж Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрээр тус тус батлуулах шатанд байна.	03.12-06.06	80%
<b>Зорилт 2. “БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</b>							
1.	Арга хэмжээ 2.1. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд бусад байгууллага, иргэнтэй байгуулах гэрээ хэлэлцээр, санамж бичгийн төслийг хянана.	Гэрээ хэлэлцээр, санамж бичгийн үндэслэл, найруулгыг хянасан байна.	-	30%	Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан Үйлчилгээний 19, Ажил гүйцэтгэх 4, Түрээсийн 5, Худалдах худалдан авах 4, яамны үндсэн үйл ажиллагаатай холбоотой 5 гэрээ тус тус баталгаажсан. Гэрээний төсөл болон гэрээ дүгнэсэн акт түүнтэй холбогдох гэрээний хэрэгжилтийг тухай бүрд хянаж, найруулгын болон эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэн ажилласан.	03.12-06.06	80%
2.	Арга хэмжээ 2.2. Гэрээний бүртгэл үйлдэнэ.	Гэрээний бүртгэлийн тоо	-	30%	Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд нийт 37 гэрээг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй байгуулсныг бүртгэл хөтлөн дугаар өгч ажилласан.	03.12-06.06	80%

3.	Арга хэмжээ 2.3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туссан нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээний биелэлтийн мэдээг танилцуулах, удирдлагыг мэдээллээр хангана.	Гэрээний хэрэгжилтийн талаар тайлан гаргасан байна.	-	40%	Тус яамны “Гэрээ байгуулахад мөрдөх дотоод журам”-ын 7.3-т заасны дагуу гэрээг байгуулсан нэгжийн холбогдох албан тушаалтан болон гэрээний төсөл боловсруулан батлуулсан албан хаагчдаас 2025 оны 1 дүгээр улиралд байгуулсан гэрээний хэрэгжилтийн тайланг нэгтгэн авч нэгжийн даргаас Төрийн нарийн бичгийн даргын шуурхайн хуралдаанд танилцуулсан. Мөн 2 дугаар улирлын гэрээний хэрэгжилтийн тайланг нэгтгэн боловсруулж танилцуулхаар бэлтгэж байна.	03.12-06.06	80%
----	---	---	---	-----	--	-------------	-----

**Зорилт 3. “Шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, эрх бүхий байгууллагаас шаардсан баримт материалыг хүргүүлэх ”**

1	Арга хэмжээ 3.1. Сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээнд гаргасан шийдвэртэй холбогдох эрх зүйн маргааныг хууль, шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагыг төлөөлөн оролцох	Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилж шүүхийн байгууллагад үүссэн хэрэг маргаанд оролцсон байх	-	20%	Бүх нийтийн үүргийн сангийн авлагатай аж ахуйн нэгж байгууллагуудад нэхэмжлэл гаргахаар ажиллаж байна.	03.12-06.06	30%
2	Арга хэмжээ 3.2. Шүүх, цагдаа, эрх бүхий байгууллагаас шаардсан баримт материалыг хуулийн хугацаанд нь хүргүүлэх ажлыг зохион байгуулах	Шүүх, цагдаа, эрх бүхий байгууллагаас шаардсан баримт материалыг хүргүүлэх ажлыг зохион байгуулах	-	30%	Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн шинжээчийн дүгнэлт гаргуулах тухай 3658 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг судлан тус албан бичгийн хүрээнд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 03/1398 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн бөгөөд шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас татгалзсан тухай тайлбарыг хүргүүлсэн.	03.12-06.06	60%

**Зорилт 4. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд**

1	Арга хэмжээ 4.1. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, нэгжийн даргаар батлуулж хэрэгжүүлэх	-	50%	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан нэгжийн даргад танилцуулж, 2025 оны 03 дугаар сарын 12-ний өдөр батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу арга хэмжээний биелэлтийг ханган ажиллаж байна.	03.12-06.06	50%
2	Арга хэмжээ 4.2. Чиг үүргийн дагуу төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь чанартай гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд гаргах	-	50%	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь чанартай гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлж хамтран ажиллаж байна. 1. Удирдлагаас цохолт хийсэн албан бичигтэй тухай бүр танилцан хариу албан бичгийг хуулийн хугацаанд хүргүүлсэн. Тайлант хугацаанд 26 албан бичигт хариу хүргүүлсэн.	03.12-06.06	80%
3	Арга хэмжээ 4.3. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг хугацаанд нь, бүрэн архивлах	Гүйцэтгэсэн ажлын баримтыг архивын нэгж болгон бэлтгэж, архивд шилжүүлэх	-	50%	Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй 2024 онд байгуулсан гэрээг архивын нэгж болгон Архив, бичиг хэргийн мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.	03.12-06.06	80%
4	Арга хэмжээ 4.4. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэх	Удирдлагаас цохож шилжүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх	-	50%	Удирдлагаас цохсон өргөдөл гомдлын хариуг ERP системд бүртгэсэн хугацаанд хүргүүлэхээр ажиллаж байна.	03.12-06.06	80%
5	Арга хэмжээ 4.5. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон	1.ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд	-	50%	Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын байдлыг томилогдсоноос хойш 30 хоногийн	03.12-06.06	80%

хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	шинэчлэн мэдүүлэх			дотор цахим системд мэдүүлж, 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр баталгаажуулсан.		
---	-------------------	--	--	---	--	--

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
				Эхний хагас жил		
	1	2	3	4	5	6
1	Салбарын болон чиг үүргийн хүрээнд явагдах семинар, өдөрлөг, сургалтуудын зохион байгуулалт, олон нийтийн ажилд идэвхтэй оролцох	Холбогдох байгууллагаас зохион байгуулж байгаа сургалтад хамрагдсан байна.	-	Тус яам болон Үндэсний Дата төв УТҮГ-ийн хамтран 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан "Дата төвийн боломж-Сорилт" сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон.	03.12-06.06	50%
2	Байгууллагад зохион байгуулж байгаа сургалт, олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй хамрагдах	Зарлагдсан сургалт, арга хэмжээнд тухай бүр хамрагдсан байна.	-		03.12-06.06	50%

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Салбарын эрх зүйн асуудал хариуцсан  
мэргэжилтэн  
(Албан тушаал)

О.Мөнхзаяа /  /

( Нэр, гарын үсэг )

2025.06.06

( Огноо )